



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

“Изи Инвестмэнт” ХХК-д  
даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Изи Инвестмэнт” ХХК-д ердийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Изи Инвестмэнт” ХХК /Д.Мөнхзолбоо/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001596